



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/176

Мөрөн сум

Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт  
оруулж, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 1 иргэн, 1 аж ахуйн нэгжийн гаргасан хүсэлтийн дагуу 0.066га (0.0660м<sup>2</sup>) газрын газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 26-ны өдрийн  
А/176 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Иргэндийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Өөрчилж, нэмэлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	Харуул овгийн Баярсайхан Буян-Арвижих /РГ86092113/	6712015889	6-р баг "Магнай трейд" ШТС-ын хойно	Аймгийн Засаг даргын 2020.05.04-ний өдрийн А/260 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалтын 6 дахь баганын "373м <sup>2</sup> " гэснийг "497м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /сунгалт/
2	"Хаан банк" ХХК-Банк /РД:2693321/	6712014602	5-р баг "Хөвсгөл-Эх" захын урд	Аймгийн Засаг даргын 2019.03.22-ны өдрийн А/118 дугаар захирамжийн хавсралтын 5 дахь заалтын 6 дахь баганын "150м <sup>2</sup> " гэснийг "163м <sup>2</sup> " гэж	Газрын талбайн хэмжээ өөрчлөх /сунгалт/

Нийт талбайн хэмжээ-660м<sup>2</sup>

-----oOo-----